



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.07.03 № 269
танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд

заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Дархан-Уул аймгийн "Монгол ардын нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Дархан-Уул аймгийн "Монгол ардын нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит, Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Дархан-Уул аймгийн "Монгол ардын нам"-ын орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Дархан-Уул аймгийн "Монгол ардын нам"-ын мөрийн хөтөлбөр (26 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Дархан-Уул аймгийн "Монгол ардын нам"-д

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /Ш.МӨНХБАЯР/



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
МОНГОЛ АРДЫН НАМ

АЙМАГ, СУМЫН ИТХ-ЫН 2024 ОНЫ 9 ДЭХ УДААГИЙН
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ДЭВШҮҮЛСЭН

ТОГТВОРТОЙ БОДЛОГО - ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ
ШИНЭ СЭРГЭЛТ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР
ХТ05438-9-9022899
(2024-2028)

2024 он

АГУУЛГА

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 1.1 Эрүүл мэнд
- 1.2 Боловсрол, шинжлэх ухаан
- 1.3 Хүн ам, нийгмийн зорилтот бүлэг
- 1.4 Хөдөлмөр эрхлэлт
- 1.5 Амьдрах орчин
- 1.6 Соёл урлаг, спорт

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО

- 2.1 Төсөв, мөнгөний бодлого
- 2.2 Бизнес, хөрөнгө оруулалтын орчин
- 2.3 Банк, санхүү, даатгал, хөрөнгийн зах зээл

ГУРАВ. ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН ба НОГООН ХӨГЖЛИЙН СЭРГЭЛТ

- 3.1 Байгаль хамгаалал
- 3.2 Ногоон эдийн засаг
- 3.3 Ногоон үйлдвэрлэл, үйлчилгээ

ДӨРӨВ. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨГЖИЛ ба АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН СЭРГЭЛТ

- 4.1 Боловсруулах үйлдвэр
- 4.2 Хөнгөн ба хүнсний үйлдвэр
- 4.3 Хоршоо, жижиг, дунд үйлдвэр
- 4.4 Өрхийн үйлдвэрлэл
- 4.5 Үйлчилгээний салбар
- 4.6 Борлуулалт, зах зээл

ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ ба ХОТ, ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТ

- 5.1 Зөв төлөвлөлт, ээлтэй орчин

5.2. Орон сууц ба гэр хороолол

5.3. Эрчим хүч, шугам сүлжээ

5.4. Тээвэр, авто зам

5.5 Сумдын хөгжил

ЗУРГАА. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО ба ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙН СЭРГЭЛТ

6.1 Иргэдэд ээлтэй төрийн үйлчилгээ

6.2 Ухаалаг төрийн үйлчилгээ

6.3 Эрх зүй, батлан хамгаалах, гамшгаас хамгаалах бодлого

6.4 Төрийн албаны хүний нөөцийн бодлого ба нийгмийн баталгаа



(Нийт 6 бүлэг, 27 дэд бүлэг, 271 зорилт)

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Хүний хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд болох эрүүл мэнд, боловсрол, нийгмийн бусад суурь үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, иргэн бүрт тэгш боломж бий болгож, хүний амьдрах таатай орчин нөхцлийг бүрдүүлэхэд онцгой анхаарч, өрх, иргэдээ тогтмол ажилтай, орлоготой байхад бүх талаар дэмжлэг үзүүлж, хүний амьдралын чанарыг сайжруулна.

1.1 Эрүүл мэнд

1.1.1. “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.1.2. “Эрүүл Дарханчууд” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.1.3. “Хавдаргүй Дархан” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.1.4. Хүүхдийн “Эрүүл шүд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.1.5. Эмнэлгийн тусламж, үйлчилгээг ил тод, хариуцлагатай байлгаж, шуурхай хүргэх зорилгоор өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт мэдээлэх, сануулах хиймэл оюун ухаанд суурилсан системийг хөгжүүлж, салбарын цахим шилжилтийг эрчимжүүлж, “Шилэн эмнэлэг”, “Цахим эмнэлэг” төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.1.6. Орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, олон улсын түвшний мэргэжлийн өндөр чадавхитай боловсон хүчнээр хангагдсан бүсийн хэмжээний лавлагаа шатлал (3 дугаар шатлал)-ын “Нэгдсэн эмнэлэг”-ийг барьж ашиглалтанд оруулна.

1.1.7. Эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлгийг оновчтой, эрсдэлд суурилсан байдлаар тасралтгүй үргэлжлүүлнэ.

1.1.8. Эрх бүхий байгууллага, албан тушаалтантай хамтран эрүүл мэндийн даатгалын шинэчлэлийг хийх замаар иргэдэд ирэх санхүүгийн дарамтыг багасгана.

1.1.9. Эрүүл мэндийн даатгалыг багцын системд шилжүүлж, даатгуулагч өөрт хэрэгцээтэй багцыг сонгодог тогтолцоонд шилжинэ.

1.1.10. Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл, зөв хооллох, өвчнөөс урьдчилан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлнэ.

1.1.11. Эрүүл мэндийн салбарт дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах замаар материаллаг баазыг нэмэгдүүлж, эмчилгээ, оношилгооны чанар, хүртээмжийг сайжруулна.

1.1.12. Өрхийн эрүүл мэндийн төвийг нэмж байгуулах замаар ачааллыг бууруулна.

1.1.13. Хүн амын дунд зонхилон тохиолддог өвчний тандалт, судалгааны дүнд үндэслэн хариу арга хэмжээний төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлнэ.

1.1.14. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлыг онцгой анхаарч, эх, хүүхдийн эндэгдлийг бууруулна.

1.1.15. Эрэгтэйчүүд, оюутан залуучууд, явуулын болон ээлжийн ажиллагсад гэх мэтбүлгүүд рүү чиглэсэн эрүүл мэндийн тусгайлсан үйлчилгээг үзүүлнэ.

1.1.16. Монгол Улсад эмчлэгдэх боломжгүй өвчин, эмгэгийн улмаас зайлшгүй гадаад улсад эмчлүүлэх иргэдэд дэмжлэг үзүүлнэ.

1.1.17. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед авах хариу арга хэмжээний чадавхийг нэмэгдүүлнэ.

1.1.18. Эрүүл мэндийн салбарын ажиллагсдыг тогтмол чадавхижуулж, дутагдалтай байгаа нарийн мэргэжилтнүүдийг гадаад, дотоодод захиалгаар бэлтгэнэ.

1.1.19. Салбарын ажиллагсдын ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Тогтвортой ажилтан” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.1.20. Эм зүйн салбарт тавих хяналтыг чангатгаж, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн чанар, стандартыг хангуулахад онцгой анхаарна.

1.1.21. Хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах чиглэлээр өмчийн бусад төрлийн эмнэлэгүүдийг дэмжиж, хамтран ажиллана.

1.1.22. Уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх бодлого баримтална.

1.2. Боловсрол, шинжлэх ухаан

1.2.1. “Боловсрол -2032” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.2.2. “Оюунлаг Дарханчууд-3” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.2.3. “Цахим сургууль”, “Гоё сургууль”, “Гоё цэцэрлэг” төслүүдийг үргэлжлүүлнэ.

1.2.4. “Багшийн хөгжил” хөтөлбөрийг шинээр, “Чадварлаг багш” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.2.5. “Багш хөгжлийн төв”-ийн үйл ажиллагааг өргөтгөж, бүсийн түвшнийх болгоно.

1.2.6. Хүн амын өсөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан байршлыг оновчтой тогтоон сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлж, анги, бүлэг дүүргэлтийг стандарт хэмжээнд хүргэнэ.

1.2.7. Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, 1-2 насны хүүхдийг яслийн үйлчилгээнд хамруулах боломжийг бүрдүүлнэ.

1.2.8. Ерөнхий боловсролын масс сургалтын чанарын үнэлгээний гүйцэтгэлийн хувийг нэмэгдүүлнэ.

1.2.9. Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадаагүй, зорилтот болон эрсдэлт бүлгийн суралцагчдад шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролын үйлчилгээнд хамрагдах боломжийг бий болгоно.

1.2.10. Цэцэрлэг, сургуулийн материаллаг баазыг нэмэгдүүлж, гадна, дотор орчныг камержуулж, хүүхэд эрүүл, аюулгүй орчинд сурч, хүмүүжих нөхцөлийг бүрдүүлнэ.

1.2.11. Сургуулиудын номын санг шинэчилж, бүх сургуулиудад лаборатори, зарим сургуулиудад туршилтын талбай шинээр байгуулна.

1.2.12. Цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоолны орц, найрлагыг тогтмол хянаж, шим тэжээл, амин дэмээр баялаг хоолоор үйлчилнэ.

1.2.13. Боловсролын салбарын багш, ажилчдын ажиллах нөхцөлийг сайжруулж, нийгмийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.


1.2.14.Багшийн ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, багш, сурагчдын үзүүлсэн амжилтыг үнэлэх урамшууллын механизмыг боловсронгуй болгоно.

1.2.15. Цахим болон зайны сургалтын платформыг хөгжүүлж, хүн бүр цаг хугацаа, орон зайнаас үл хамааран өөрийн хүссэн чиглэлээр насан турш суралцах боломжийг бүрдүүлнэ.

1.2.16. Хүүхдийн автобусны тоог нэмэгдүүлж, бүх чиглэлд үйлчилгээ үзүүлнэ.

1.2.17.“Хүүхэд хөгжлийн ордон”-ы үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

1.2.18. Хичээлээс гадуурх секц, дугуйлангуудыг бодлогоор дэмжиж, хүүхдийг өөрийн авьяаст нь тулгуурлан хөгжүүлж, амьдралын зөв дадалд сургах бодлого баримтална.



1.2.19. Нийгмийн амьдрал, орон нутгийн хөгжилд хүүхдүүдийн оролцоог идэвхжүүлэх зорилгоор “Хүүхдээ сонсоё” аяныг хэрэгжүүлнэ.

1.2.20. Өмчийн бусад хэлбэрийн сургалтын байгууллагуудтай хамтран ажиллана.

1.2.21. Бүс, орон нутгийн хөгжлийн асуудлаар шинжлэх ухаан, инновацийн судалгаанд бүх талын дэмжлэг үзүүлж, эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуулиуд, эрдэмтэдтэй хамтран ажиллана.

1.2.22. Орон нутагт эрэлттэй болон дутагдалтай байгаа мэргэжилтнийг гэрээний үндсэн дээр захиалгаар бэлтгэнэ.

1.2.23.Шинжлэх ухааны ололт, шинэ технологи, инновацийг хөгжүүлэх,үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж, хувийн хэвшилтэй хамтран ажиллана.


1.2.24. Бүс, орон нутгийн хөгжлийн онцлогт тохирсон шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын судалгаанд төсвөөс зарцуулах санхүүжилтийг үе шаттай нэмэгдүүлнэ.

1.2.25. Дээд боловсролын сургалт – эрдэм шинжилгээ – үйлдвэрлэлийн цогцолборыг төрөлжүүлэн хөгжүүлэх чиглэлээр “Хөдөө аж ахуйн их сургуулийн хотхон”-ыг байгуулна.

1.2.26. Бүсийн эдийн засгийн тэргүүлэх чиглэл, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагуудыг түшиглэн “Дундын дадлага, үйлдвэрлэлийн бааз” байгуулна.

1.2.27. Аймаг, сумдын Тамгын газар, зарим төрийн байгууллагын дэргэд “Эрдэмтдийн зөвлөл” байгуулж ажиллуулна.

1.2.28. Нэн шаардлагатай болон ховор мэргэжлээр суралцаж буй оюутан, залуучуудад зориулж “Орон нутгийн тэтгэлэг” хөтөлбөр хэрэгжүүлнэ.



1.3. Хүн ам, нийгмийн зорилтот бүлэг

1.3.1. Аймгийнхаа хүний хөгжлийн индексийг тооцоолон гаргасны үндсэн дээр “Хүний хөгжил” хөтөлбөрийг шинэчилэн боловсруулж хэрэгжүүлнэ.

1.3.2. Аймгийн нийт өрх, хүн амын амьдралын чанар, амьжиргааны түвшнийг тодорхойлон гаргаж, төрөөс нийгмийн хамгааллын бодлого боловсруулахад ашиглана.

1.3.3. Хүн ам зүйн нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

1.3.4. Төрөөс үзүүлж буй нийгмийн халамжийн үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.

1.3.5. Гэр бүлийн үнэт зүйлсийг эрхэмлэн дээдэлж, өрхийн гишүүдийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлж, гэр бүл дэх хүчирхийллийг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

1.3.6. Залуу гэр бүлийг олон талт арга хэлбэрээр дэмжиж, залуучуудын, гарааны бизнесээ эхлэх, бизнес эрхлэх боломж, нөхцлийг нэмэгдүүлнэ.

1.3.7. Хүүхэд, залуучууд, ахмад, эмэгтэйчүүд болон тусгай хэрэгцээт иргэдийн “Төрөлжсөн төвүүд”-ийн үйл ажиллагааг дэмжинэ.

1.3.8. Хүүхдийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж, тэдэнд зориулсан нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулж, сум, баг бүрт гэр бүл, хүүхдийн хөгжил хариуцсан нийгмийн ажилтан ажиллуулна.

1.3.9. Ганц бие, өрх толгойлсон эх, эцэг, олон хүүхэдтэй, тогтмол орлогогүй болон орлого багатай өрх, иргэдийг бүхий л талаар дэмжинэ.

1.3.10. “Эрүүл чийрэг эр хүн” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, эрэгтэйчүүдийг аливаа эрсдэлт хүчин зүйлсээс хамгаалах бодлого баримтална.

1.3.11. Тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан дэд бүтцийн стандартыг бүх газарт мөрдүүлнэ.

1.4. Хөдөлмөр эрхлэлт

1.4.1. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг үргэлжлүүлж, ажилгүйдлийн түвшинийг тодорхой хувиар бууруулна.

1.4.2. “Халамжаас хөдөлмөрт” хөтөлбөрийг хэрэгжүүлж, халамж хүртэгсдийн тоог шат дараатай бууруулна.

1.4.3. Бага орлогтой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг бодлогоор дэмжинэ.

1.4.4. Шинээр ажлын байр бий болгосон, эдийн засгийн хүнд нөхцөлд ажлын байраа хадгалсан ажил олгогчдыг хөхиүлэн дэмжинэ.

1.4.5. Бага насны хүүхэдтэй өрхийн гишүүд, ахмад настан, тусгай хэрэгцээт иргэд, оюутан, залуучууд богиносгосон цагаар болон зайнаас ажиллах уян хатан зохицуулалтыг бий болгоно.

1.4.6. “Цалинтай эх, эцэг” хөтөлбөрийг нийгмийн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан боловсруулж, хэрэгжүүлнэ.

1.4.7. Ахмад настны болон тусгай хэрэгцээт иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

1.4.8. Оюутан, залуучуудад зориулсан “Цагийн ажил” төслийг үргэлжлүүлнэ.

1.4.9. Ажил олгогчдын захиалгын дагуу орчин үеийн шаардлага хангасан нарийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэнэ.


1.4.10. Ажилгүй иргэдэд мэргэжлийн чиг баримжаа олгох богино хугацааны сургалтуудыг зохион байгуулна.

1.4.11. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, зээл, арга хэмжээг санхүүжүүлэхдээ шинээр бий болгох ажлын байрны тоог харгалзана.

1.4.12. Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг дэмжсэн зээлийн сангийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.4.13. Мэдлэг, туршлагыг нь залуучуудад өвлөн үлдээлгэх зорилгоор “Ахмадаас суралцъя” аян өрнүүлнэ.

1.4.14. Нутаг дэвсгэртээ хөдөлмөрийн норм, нормативийг чанд мөрдүүлж, ажил олгогч, ажиллагсдын эрх ашгийг харилцан хамгаалах чиглэлээр Үйлдвэрчний байгууллагатай хамтарч ажиллана.



1.5. Амьдрах орчин

1.5.1. Иргэдийнхээ амьдрах орчныг сайжруулах чиглэлээр тусгай төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлнэ.

1.5.2. Агаар, ус, хөрсний бохирдол, дуу чимээг багасгаж, суурьшлын бүсэдхүн амьдрахад таатай цэвэр орчныг бүрдүүлнэ.

1.5.3. Иргэд амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд зориулсан ногоон байгууламж бүхий бичил орчныг хорооллуудад байгуулна.

1.5.4. Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.

1.5.5. Хог тээвэрлэлтийн менежментийг сайжруулж, “Хоггүй хот” төсөл хэрэгжүүлнэ.

1.5.6. “Эрсдэлгүй Дархан” аяныг үргэлжлүүлнэ.

1.5.7. Авто замын гэрлэн дохиог нэмэгдүүлж, хурд сааруулагч, гарцын тэмдэг, тэмдэглэгээг тогтмол сайжруулж, явган зорчигчид, ялангуяа хүүхдүүд замын хөдөлгөөнд аюулгүй оролцох нөхцлийг бий болгоно.


1.5.8. Хүн амын суурьшлын бүс, орон сууцны хорооллууд, сургууль, цэцэрлэг, ахмад настан, хүүхдүүдэд зориулсан объект, тусгай бүсэд хэт ойр баар, цэнгээний газар ажиллуулахыг зогсооно.

1.5.9. Барилга байшин барих, авто зам, шугам сүлжээ шинээр тавих, засвар үйлчилгээ хийх зэрэг бүтээн байгуулалтын ажлын үеэр аюулгүй байдлын стандарт, нормативыг чанд мөрдүүлнэ.

1.5.10. Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, Сууц өмчлөгчдийнхолбоотой хамтран нийтийн орон сууцуудын засвар, үйлчилгээг хийж, иргэдийн амьдрах нөхцлийг сайжруулна.

1.5.11. Суурьшлын бүсүүдийн гэрэлтүүлэг, камержуулалтыг иж бүрэн шийдвэрлэнэ.

1.5.12.Мал, амьтны халдварт өвчингүй, тайван “Хамгаалалттай бүс” байгуулах мэргэжлийн байгууллага, хувийн хэвшлийн үүсгэл санаачилгыг дэмжиж, хүнсний аюулгүй байдлыг хангуулна.



1.6. Соёл урлаг, спорт

1.6.1. “Номын сан, музейн цогцолбор”- ыг ашиглалтандордуулна.

1.6.2.“Биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг үргэлжлүүлнэ.

1.6.3.Мэргэжлийн урлагийн байгууллагын үйл ажиллагааг тогтмол дэмжиж, шинэ уран бүтээлийн тоог нэмэгдүүлнэ.

1.6.4.“Кинонд ээлтэй хот” төслийг хэрэгжүүлж, кино, контент үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

1.6.5.Аймаг, хотын нэрэмжит соёл, урлагийн брэнд, эвент арга хэмжээнүүдийг уламжлал болгон зохион байгуулна.

1.6.6. Үндэсний өв соёл, түүх, ардынуламжлалт ахуйг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, өвлүүлэн үлдээх талаар тусгай контентууд хийнэ.

1.6.7. Гадаадын ах дүүхотууд, нийслэл болон бусад бүсийн аймгуудад “Дарханы соёлын өдрүүд” урлаг, соёлын нэгдсэн арга хэмжээг 2 жил тутамд зохион байгуулж хэвшинэ.

1.6.8. Соёл, урлагийг хөгжүүлэх, ард иргэдийг соён гэгээрүүлэх чиглэлээр мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, иргэдийн үүсгэл санаачилгыг дэмжиж ажиллана.

1.6.9. Мэргэжлийн спорт болон нийтийн биеийн тамирыг дэмжин хөгжүүлнэ.

1.6.10. Спорт тоглоомын талбайд, чийрэгжүүлэлтийн тоноглолуудыг нийтийн эзэмшлийн газрууд, цэцэрлэгт хүрээлэнгүүд болон хорооллуудад барьж байгуулна.

1.6.11. Бүх сургуулиудын спорт заал, биеийн тамирын талбайг орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинэчилнэ.

1.6.12. Аймаг, орон нутагтаа зохион байгуулах олон улс, хотууд, улсын аваргын уралдаан, тэмцээний төрөл, тоог нэмэгдүүлж, тогтмолжуулна.

1.6.13. Спортын мэргэжлийн холбоодыг дэмжиж ажиллана.

1.6.14. Тусгай хэрэгцээт хүмүүсийг спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх боломжоор хангана.

1.6.15. Соёл урлаг, спортын салбарт гаргасан амжилт гаргасан хүмүүсийг үнэлэнурамшуулж, алдаршуулна.

1.6.16. “Спорт, урлагийн төрөлжсөн сургууль”-иудбайгуулна.

1.6.17. “Биеийн тамир, спортын бүсийн хөгжлийн төв” байгуулна.

1.6.18. Өвлийн спортын төрлүүдийг хөгжүүлж, “Мөсөн ордон” байгуулна.

1.6.19. Нийтийн биеийн тамир, спортын хөгжлийг орчин үеийн дэлхий нийтийн чиг хандлагатай уялдуулан хөгжүүлэх чиглэлээр авто болон цахим спортын төрлүүдийг хөгжүүлнэ.

1.6.20. Соёл урлаг, спортын салбарын хүний нөөцийг бодлогоор бэлтгэж, чадавхижуулна.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО

Төсвийн сахилга батыг чанд сахиж, хөрөнгө оруулалт, банк, санхүү, даатгалын оновчтой зөв бодлого хэрэгжүүлж, бизнесийн таатай орчныг бий болгоно.

2.1 Төсөв, санхүү, эдийн засаг

2.1.1. Төсвийг үндэслэлтэй төлөвлөх зорилгоор иргэд, төрийн бус байгууллагын оролцоог хангуулна.

2.1.2. Төсвийн сахилга батыг чанд сахиж, төсвийн хяналтыг сайжруулна.

2.1.3. Төсвийн ил тод байдлыг хангуулж, “Шилэн данс”-ыг 100 хувь хөтлүүлж хэвшүүлнэ.

2.1.4. Төсөл, тендер, сангуудаас олгох зээлийн шалгаруулалтыг ард иргэд, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын хяналтан доор олон нийтэд ил тод, нээлттэй явуулж, хяналтыг чангатгана.

2.1.5. Төрийн зарим үйлчилгээг ажлын үр дүн, гүйцэтгэлээр санхүүжүүлдэг тогтолцоонд шилжинэ.

2.1.6. Эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх бүхий л боломжийг судалж хэрэгжүүлнэ.

2.1.7. Эдийн засгийн тэргүүлэх салбаруудаа эрэмбэлэн тодорхойлж, бодлогоор дэмжинэ.

2.1.8. Өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.

2.2 Бизнес, хөрөнгө оруулалтын орчин

2.2.1. Бизнесийн болон хөрөнгө оруулалтын хамгийн таатай орчныг бүрдүүлнэ.

2.2.2. Төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг үр өгөөжөөр нь эрэмбэлж, эхний ээлжинд эдийн засгийн үр өгөөжтэй, ажлын байр шинээр бий болгох ажлуудыг санхүүжүүлэх зарчим баримтална.

2.2.3. Бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог аль болох хязгаарлана.

2.2.4. Төрөөс бизнесийн тусгай зөвшөөрлийг шинээр олгох, сунгах үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, хүний оролцоогүй болгоно.

2.2.5. Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлж, гэрээгээр гүйцэтгүүлнэ.

2.2.6. Аймаг, орон нутгаас тогтоодог төлбөр, хураамжийн хувь хэмжээг аль болох багаар тогтоож, бизнес эрхлэгчдэд үзүүлэх дарамтыг багасгана.

2.2.7. Нийтийн эзэмшлийн зам талбай, цэцэрлэгт хүрээлэн, гол гол авто замын дагуу иргэдэд үйлчилгээний бизнес эрхлэх боломж олгоно.

2.2.8. Иргэд хөдөлмөрөө хорших, хамтрах нөхцлийг бүрдүүлж, хамтын бизнесийг нь бодлогоор дэмжинэ.

2.2.9. Аймаг, орон нутгийн тэргүүлэх салбарт оруулж буй гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг төрөөс бодлогоор дэмжинэ.

2.3 Банк, даатгал, хөрөнгийн зах зээл

2.3.1. Банкны үйлчилгээг иргэд, бизнес эрхлэгчдэд ойртуулж, үйлчилгээний нөхцлийг сайжруулж, зээлийн эх үүсвэр, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр арилжааны банкуудтай хамтарч ажиллана.

2.3.2. Даатгалын үйлчилгээг хөгжүүлж, иргэн, аж ахуйн нэгжид учирч болох эрсдлийг бууруулна.



2.3.3. Хөдөө аж ахуйн салбарт даатгалын үйлчилгээг түлхүү нэвтрүүлнэ.

2.3.4. Орон нутагт хөрөнгийн зах зээлийг хөгжүүлж, иргэд нэмэлт орлого олох боломжийг бүрдүүлнэ.

ГУРАВ. ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН ба НОГООН ХӨГЖЛИЙН СЭРГЭЛТ

Хүрээлэн буй орчинд ээлтэй ногоон хөгжлийг бүхий л талаар дэмжинэ.

3.1 Байгаль хамгаалал

3.1.1. “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөний хүрээнд “Ногоон Дархан” хөтөлбөрийг хэрэгжүүлж, 20,0 саяас доошгүй мод тарина.

3.1.2. Ногоон хөгжлийн сэргэлтийн хүрээнд дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлнэ.

3.1.3. Байгаль орчин, уур амьсгалын сөрөг үр нөлөөг бууруулах чиглэлээр гадаад, дотоод эх үүсвэрүүдээс төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ.

3.1.4. Ус, хөрс, ойн сан, бэлчээрийг хамгаалж, газрын доройтлоос сэргийлж, цөлжилттэй тэмцэнэ.

3.1.5. Агаарын бохирдлыг бууруулна.

3.1.6. Ургамал, амьтны тархац, нөөцийн судалгааг хийж, ховордсон төрөл зүйлийг хамгаална.

3.1.7. Байгалийн нөхөн сэргээлтийг хийж, газрын доройтлыг бууруулна.

3.1.8. Гол, нуур, булаг, шандны эхийг хамгаалж, хиймэл нуур, хөв цөөрөм байгуулж, гүний усны нөөц ашиглалтыг хязгаарлах бодлого баримтлана.

3.1.9. Иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлж, хүүхэд, залуучуудад багаас нь хүрээлэн буй орчноо хайрлан хамгаалах зөв дадал хэвшил суулгаж, экологийн мэдлэг олгоно.

3.2 Ногоон эдийн засаг



3.2.1. Ногоон хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

3.2.2. Байгаль хамгаалах үйлсэд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг татан оролцуулж, хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах тогтолцоог бий болгоно.

3.2.3. Ногоон санхүүжилт, зээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.2.4. Ногоон хэрэглээг нэмэгдүүлэх хөшүүргүүдийг бий болгож, төрийн худалдан авалтыг ногоон болгоно.

3.2.5. Хүлэмжийн хийн ялгарал, агаарын бохирдлыг бууруулахад үйл ажиллагаагаа чиглүүлж, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлнэ.

3.2.6. “Утаагүй Дархан”, “Шарилжгүй Дархан” хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

3.2.7. Салхи, шуурганы хүч хурдыг бууруулах, хөрсний эвдрэл, элэгдэл, цөлжилтөөс хамгаалах “Ногоон хэрэм”, “Ойн зурвас”-уудыг байгуулна.

3.2.8. Авто болон төмөр зам, гол гудамжны дагуу чимээ шуугиан, орчны бохирдлоос хамгаалсан “Хамгаалалтын зурвас” байгуулна.

3.2.9. Эко аялал жуулчлалыг хөгжүүлж, усан парк, гольфын талбай бүхий “Амралт, зугаалгын бүс” байгуулахыг бодлогоор дэмжинэ.

3.2.10. “Ботаникийн болон ховор ургамлын цэцэрлэгт хүрээлэн” байгуулна.

3.3 Ногоон үйлдвэрлэл, үйлчилгээ


3.3.1. Ухаалаг, хэмнэлттэй хэрэглээг дэмжиж, байгаль орчинд ээлтэй ногоон үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлнэ.

3.3.2. Хог хаягдлыг дахин боловсруулах “Бага оврын үйлдвэр” барина.

3.3.3. Үйлдвэрлэлд ашигласан усыг дахин ашиглах санал, санаачилгыг дэмжиж, авто угаалга, гудамж талбайн ариутгал, ногоон байгууламжийн усалгаа зэрэг үйлчилгээнүүдийг “Саарал ус” ашиглах технологид шилжүүлнэ.

3.3.4. Ногоон технологи, инноваци, судалгаа шинжилгээний ажил, гарааны бизнес, ногоон хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

3.3.5. Нэгэнт олгогдсон ашигт малтмалын лиценз, зөвшөөрлийн хүрээнд хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, нутаг дэвсгэртээ дахин лиценз олгуулахгүй байх талаар бүхий л талын арга хэмжээг авч ажиллана.



3.3.6. Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрчим хүчний хэмнэлтийн технологийг нэвтрүүлэхийг дэмжинэ.

3.3.7. Байгальд ээлтэй эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй ногоон барилга байгууламжийг нэмэгдүүлнэ.

3.3.8. Байгаль орчинд ээлтэй эко авто машины хэрэглээг нэмэгдүүлж, нийтийн тээврийг цахилгаанаар ажилладаг горимд бүрэн шилжүүлнэ.

3.3.9. Хог хаягдлын хуучин цэгүүдийг байгаль орчинд ээлтэй дэвшилтэт аргаар дарж устган хогийг эх үүсвэр дээр нь ангилж, ”Тусгай хог хаягдлын цэг” байгуулна.

3.3.10. Хөдөө аж ахуйн эдэлбэр газрын ашиглалтыг сайжруулна.

ДӨРӨВ. ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХӨГЖИЛ ба АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН СЭРГЭЛТ

Аж үйлдвэржилтийн сэргэлтийн хүрээнд үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

4.1 Хүнд болон боловсруулах үйлдвэр

4.1.1. Аж үйлдвэржилтийн сэргэлтийн хүрээнд нэмүү өртөг шингэсэн, уул уурхай, хөдөө аж ахуйн эцсийн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрүүдийг байгуулахыг бодлогоор дэмжинэ.


4.1.2. Бүсийн хэмжээнд “Монгол ган” төсөлтэй хамтран ажиллаж, “Гангийн үйлдвэр” барьж байгуулахыг бодлогоор дэмжинэ.

4.1.3. “Дархан арьс, ширний цогцолбор” төслийг үргэлжлүүлнэ.

4.1.4. Түүхий эдийн байгалийн ордуудад түшиглэн барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

4.1.5. Хувийн хэвшилтэй хамтран “Хүнд үйлдвэрлэлийн технологийн парк” байгуулна.

4.1.6. Хөдөө аж ахуйн “Техник, тоног төхөөрөмж угсрах үйлдвэр” байгуулахыг бодлогоор дэмжинэ.



4.2 Хөнгөн ба хүнсний үйлдвэр

4.2.1. Хувийн хэвшилтэй хамтран “Хөнгөн үйлдвэрлэлийн технологийн парк” байгуулна.

4.2.2. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалтын түвшинг нэмэгдүүлнэ.

4.2.3. Арьс, шир, ноос, ноолууран эдлэл, оёмол, нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

4.2.4. “Хүнсний хувьсгал” хөтөлбөрийг хэрэгжүүлж, гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

4.2.5. “Атар – IY” аяныг хэрэгжүүлж, газар тариалангийн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлнэ.

4.2.6. Эрчимжсэн аж ахуйдыг дэмжин хөгжүүлнэ.

4.2.7. Мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

4.2.8. Мал, амьтны “Тэжээлийн үйлдвэр” байгуулахыг бодлогоор дэмжинэ.

4.2.9. Хүлэмж, агуулах, зоорийн аж ахуйг хөгжүүлж, хүнсний ногоо, жимс жимсгэнийн нэр төрлийг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээг тогтвортой хангана.

4.2.10. Төрөлжсөн лабораториудын хүчин чадлыг нэмэгдүүлж, шинжилгээ, баталгаажуулалтын чадавхийг сайжруулна.

4.2.11. Малаас хүнд халдварладаг халдварт өвчний тандалт, шинжилгээг өргөжүүлж, халдварлалтыг бууруулах, хянах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.3 Хоршоо, жижиг, дунд үйлдвэр

4.3.1. “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг өрнүүлж, малчид хоршиж ажиллахыг бүхий л талаар дэмжинэ.

4.3.2. Малчдад хоршоогоор дамжуулан нийгмийн үйлчилгээг үзүүлнэ.

4.3.3. Хоршоодод олгох хөнгөлөлттэй зээлийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

4.3.4. Малчдын хоршоодод тэжээлийн ургамал тариалах зориулалтаар газар олгоно.

4.3.5. Жижиг, дунд бизнесийн орон нутгийн хөгжилд үзүүлэх эдийн засгийн үүргийг нэмэгдүүлэхийг бодлогоор дэмжинэ.

4.3.6. Жижиг, дунд, бичил бизнесийг дэмжих зээл, зээлийн батлан даалтын сангийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

4.3.7. Жижиг, дунд, бичил болон гарааны бизнесийг дэмжин бойжуулах бизнес инкубацын үйлчилгээ үзүүлдэг “Бизнесийн төв” байгуулна.

4.4 Өрхийн үйлдвэрлэл

4.4.1. “Өрх бүр үйлдвэрлэгч” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

4.4.2. “Ажил олгогч өрх, иргэд”-ийг бодлогоор дэмжинэ.

4.4.3. Бичил бизнес эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.

4.5 Үйлчилгээний салбар

4.5.1. Худалдаа, үйлчилгээний салбарт чанар, стандартыг мөрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

4.5.2. Үйлчилгээний газруудад “Соёлтой үйлчилье” аян өрнүүлж, ажиллагсдын зан харилцаа, ёс зүй, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлнэ.


4.5.3. Худалдаа, үйлчилгээний салбарыг хөгжүүлэхэд шаардлагатай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, олон улсын ISO нэвтрүүлнэ.

4.5.4. Төрийн хяналт, шалгалтыг багасгаж, төрийн дарамтыг бууруулна.

4.6 Борлуулалт, зах зээл

4.6.1. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ.

4.6.2. Орон нутгийн үйлдвэрлэгчдийг дотоод, гадаадад зохион байгуулагдаж буй үзэсгэлэн худалдаа, яармагт оролцуулахад дэмжлэг үзүүлнэ.



4.6.3. “Дарханд үйлдвэрлэв” бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн санг цахим болон товхимол хэлбэрээр хийж, гадаад, дотоодын зах зээлд танилцуулах, сурталчлах ажилд дэмжлэг үзүүлнэ.

4.6.4. Дотоодын үйлдвэрлэгчдийг гадны бизнесийн өрсөлдөөнөөс хамгаалах бодлого баримтална.

ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ ба ХОТ, ХӨДӨӨГИЙН СЭРГЭЛТ

Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан аж үйлдвэр, үйлчилгээ хөгжсөн, шинжлэх ухаан, соёлын төв болгон хөгжүүлнэ.

5.1. Зөв төлөвлөлт, ээлтэй орчин

5.1.1. Засаг захиргааны зөв бүтцийг бий болгоно.

5.1.2. “Эрсдэлгүй, стрессгүй, ээлтэй, соёлтой, цэвэрхэн Дархан” хөтөлбөр хэрэгжүүлж, хүн амьдрахад “Хамгийн таатай” хот болгон хөгжүүлнэ.

5.1.3. Хотын Ерөнхий төлөвлөгөөг чанд мөрдөж, төлөвлөлтийн дагуу газар олголтыг ил тод хийж, бүрэн цахимжуулна.

5.1.4. Шинээр гэр хороолол үүсгэхгүй, хуучин гэр хорооллуудыг тэлэхгүйбайх бодлого баримталж, энэ зорилгоор газар олголтыг зогсооно.

5.1.5. Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлж, хороолол бүрт алжаал тайлах “Мини цэцэрлэгт хүрээлэн” -г үе шаттай байгуулна.

5.1.6. Үер усны гамшгийн эрсдлийн үнэлгээ хийлгэж, үерийн далан суваг, ус зайлуулах шугам сүлжээний засвар, өргөтгөл шинэчлэлийг хийнэ.

5.2. Орон сууц ба гэр хороолол

5.2.1. Орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, “Залуус хороолол”- ын бүтээн байгуулалтыг үргэлжлүүлнэ.

5.2.2. Дэд бүтцийг нь шийдвэрлэх замаар нийтийн болон амины орон сууцны хорооллуудын “Шинэ суурьшлын бүсүүд”-ийг байгуулна.

5.2.3.Иргэд түрээслэх, түрээслээд өмчлөх орон сууцны “Түрээсийн сууц” төсөл хэрэгжүүлнэ.

5.2.4. Үндсэн болон туслах тосгон, гэр хорооллын “Дахин төлөвлөлт”-ийг үргэлжлүүлнэ.

5.2.5.Гэр хорооллын зөөврийн усан сан болон гүний худгуудыг төвлөрсөн шугамд холбоно.

5.2.6. Гэр хороололд “Эко жорлон” төсөл хэрэгжүүлнэ.


5.3. Эрчим хүч, шугам сүлжээ

5.3.1. Инженерийн дэд бүтцийн өргөтгөл, шинэчлэлтийг үргэлжлүүлж, шугам сүлжээний доторлогоог хийж, ус, дулаан хангамж, эрчим хүч, цахим сүлжээний найдвартай байдлыг хангуулна.

5.3.2. “Эрчим хүчний хоёрдогч эх үүсвэр”-тэй болохыг дэмжиж, өсөн нэмэгдэж буй хэрэглээг хангах бодлого баримтална.

5.3.3. Эрчим хүч, дулааны бие даасан, тархмал эх үүсвэр байгуулах хувийн хэвшлийн үүсгэл, санаачилгыг дэмжинэ.

5.3.4.Үйлдвэрийн бүсийн инженерийн дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.



5.3.5. Дулааны цахилгаан станцын “Трубин генератор”- ыг үе шаттай шинэчилнэ.

5.3.6. Станцын дүүрсэн үнсэн сангийн талбайн асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Үнс” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

5.3.7.Цахилгаан дамжуулах “Агаарын шугамын тойрог схем”шинээр байгуулж, цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааг хангуулна.

5.3.8. Шинэ суурьшлын бүсүүдэд“Цэвэр усны өргөх станц, усан сан” болон“Дулаан хуваарилах төвүүд”- ийг мэргэжлийн байгууллагатай хамтран байгуулна.

5.3.9. Дархан сумын нийтийн зориулалттай орон сууцны ХХ, ХХII хороолол, Үндсэн тосгоны хэрэглэгчдийг “Хэрэгцээний халуун усны хаалттай систем”-д бүрэн шилжүүлнэ.

5.3.10. Дулаан Шарын гол ТӨХК-ийн дулааны станцын өргөтгөж, шинэчилнэ.

5.3.11. Алсын зайн удирдлагатай “Ухаалаг тоолуур”- ыг дулаан, усан хангамж, ариутгах татуургын үйлчилгээнд нэвтрүүлнэ.

5.4. Тээвэр, авто зам

5.4.1.Хотын доторх болон сумдын авто зам, замын байгууламж, гүүрийн шинэчлэлтийг үргэлжлүүлж, сүлжээг өргөтгөж, нэвтрэх чадварыг нэмэгдүүлнэ.

5.4.2.“Нийтийн тээврийн тусгай бодлого”боловсруулан хэрэгжүүлж, үйлчилгээг өргөжүүлж, ухаалаг системд бүрэн шилжүүлнэ.

5.4.3.“Уулзвар” төслийг үргэлжлүүлнэ.

5.4.4.Дугуйн зам” –ыг үргэлжлүүлэн барина.

5.4.5. Хувийн хэвшлийг дэмжих замаар“Олон улсын тээвэр, ложистикийн төв”- тэй болно.

5.4.6. Суурьшлын бүсэд шатахуун түгээх станц барих зориулалтаар газар олголтыг бүрэн зогсоож, автомашин, нийтийн тээврийн хэрэгслийг цахилгаанаар“Цэнэглэх станц”-уудыг байгуулахыг дэмжинэ.

5.5. Сумдын хөгжил

5.5.1. Сумдын хөгжлийн Ерөнхий төлөвлөгөөг бүсчилсэн хөгжил, хот, хөдөөгийн сэргэлттэй уялдуулан тодотгож, хөгжлийн шинэ хандлага, чиглэлийг тогтооно.

5.5.2. Орхон, Хонгор сумдад жижиг, дунд, бичил болон өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээг газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй, туслах аж ахуйтай хослуулан хөгжүүлэх бодлого баримтлана.

5.5.3. Шарын гол суманд жижиг, дунд, бичил болон өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ, хариуцлагатай уул уурхай, уламжлалт мал аж ахуйг эрчимжсэн мал аж ахуй, туслах аж ахуйтай хослуулан хөгжүүлэх бодлого баримтлана.

5.5.4. Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд сумдад орон сууцны бичил хотхон байгуулахыг дэмжиж, дахин төлөвлөлтийг эхлүүлнэ.



5.5.5. Сумдад эрүүл мэнд, боловсрол, соёл, спорт, нийтийн биеийн тамир болон төрийн үйлчилгээг жигд хүргэж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

5.5.6. Сумдын дэд бүтцийг сайжруулж, хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

5.5.7. Сумдын цэвэрлэх байгууламжийг өргөтгөж, шинэчилнэ.

5.5.8. Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, түүхий эдийг анхан шатанд боловсруулах жижиг үйлдвэрүүдийг төрөлжүүлэн байгуулна.

5.5.9. Бүх сумдад “Шинэ хөдөө”, “Бичил бизнесийг дэмжье” төслүүдийг үргэлжлүүлнэ.

5.5.10. Орхон суманд бүрэн автомат “Хүнсний ногооны зоорь” барьж ашиглалтанд оруулна.

5.5.11. Хонгор суманд “Үр үржүүлгийн төв” барьж байгуулахыг бодлогоор дэмжинэ.

5.5.12. Шарын гол суманд “Эко түлшний үйлдвэр” барьж байгуулахыг бодлогоор дэмжинэ.

5.5.13. “Шарын гол – Баянгол – Улаанбаатар” чиглэлийн авто замыг барьж дуусгана.

5.5.14. Орхон сумын Энх тал багийн төвийг Дархан – Хушаат чиглэлийн авто замтай холбоно.

5.5.15. Хонгор сумын Салхит багийн Хараа гол дээрх гүүрүүдийг шинэчилнэ.

5.5.16. Сумдад 3 улирлын “Хүлэмжийн аж ахуйн цогцолбор” барьж байгуулахыг бодлогоор дэмжинэ.


5.5.17. Малын үүлдэр угсааг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх, эрчимжүүлэх чиглэлээр мэргэжлийн байгууллагатай хамтран малчид, мал бүхий иргэд, фермерүүдийг дэмжинэ.

5.5.18. Хөдөө аж ахуйн салбарыг аливаа эрсдэлээс хамгаалах, мал, амьтныг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талаар онцгой анхаарч ажиллана.

5.5.19. Хөдөөгийн аялал жуулчлалыг хөгжүүлэхийг бодлогоор дэмжинэ.

5.5.20. Шарын гол суманд “Хүүхэд, залуучуудын хөгжлийн төв” байгуулахыг бодлогоор дэмжинэ.

5.5.21. Мал аж ахуйн салбарт тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах, мал, амьтны халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.



ЗУРГАА. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО ба ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙН СЭРГЭЛТ

Хүний эрх, эрх чөлөө, хууль эрх зүйг дээдэлж, шинжлэх ухаан, дэвшилтэт технологи, их өгөгдөлд суурилсан “Цахим засаглал”-ыг бүрэн нэвтрүүлж, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай хүргэнэ.

6.1 Иргэдэд ээлтэй төрийн үйлчилгээ

6.1.1.Төрийн чиг үүргийн давхардал, хийдэгдлийг арилгаж, цомхон, чадварлаг бүтцээр төрийн үйлчилгээг шуурхай хүргэнэ.

6.1.2.Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу байдал олгохгүй байх, явцуу сонирхол, намын харьяаллаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг хэвшүүлнэ.

6.1.3. “Иргэний индэр” –ийг тогтмол зохион байгуулж, шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

6.1.4. Төр, иргэн, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын хамтын ажиллагааг өргөжүүлж, зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодод гэрээгээр шилжүүлнэ.

6.1.5. Эдийн засаг, бизнесийн харилцаан дахь төрийн оролцоог багасгана.

6.1.6. Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, ёс зүй, хариуцлага, харилцаа хандлагыг харгалзанүр дүнг гүйцэтгэлээрүнэлдэг тогтолцоонд шилжинэ.

6.1.7. Төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг үндэс болгож, хүйсийн тэгш байдлыг хангуулна.

6.1.8. Гадаад харилцааг бүх салбарт хөгжүүлнэ.

6.2 Ухаалаг төрийн үйлчилгээ

6.2.1. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, иргэд чирэгдэлгүй үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх зорилгоор “Цахим Дархан” хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.

6.2.2. Бизнесийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг цахимаар олгоно.

6.2.3. Их өгөгдөлд суурилсан мэдээллийн нэгдсэн цахим санг байнга баяжуулж, иргэн, аж ахуйн нэгжүүд мэдээлэл авах, ашиглах, солилцох боломжийг бүрдүүлнэ.

6.2.4. Гамшигт үзэгдлээс сэргийлэх, иргэдэд мэдээлэх цахим системийг хөгжүүлнэ.

6.2.5. Цахим орчны аюулгүй байдлыг хангуулж, аливаа халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллана.

6.2.6. Хотын гэрэлтүүлэг, камержуулалт, гэрлэн дохионы хөдөлгөөн удирдлагын төвийн системд “Ухаалаг систем” нэвтрүүлнэ.

6.3 Эрх зүй, батлан хамгаалах, гамшгаас хамгаалах бодлого

6.3.1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулна.

6.3.2. Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

6.3.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангуулах, нийтийн эрх ашгийг хамгаалах ажлыг нэгдсэн төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.

6.3.4. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, авлигатай тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

6.3.5. Мансууруулах эм, ургамал, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавьж, зохисгүй хэрэглээнээс урьдчилан сэргийлнэ.

6.3.6. Согтууруулах ундааны хэрэглээ, арихидалтын улмаас хүн амын эрүүл мэндэд учирч байгаа хор уршигаас урьдчилан сэргийлэх

6.3.7. Согтууруулах ундааны хэрэглээ, арихидалтын улмаас хүн амын эрүүл мэндэд учирч байгаа хор уршигаас урьдчилан сэргийлэх

6.3.8. Гамшиг ослын үеийн бэлэн байдлыг хангаж, гамшгийн үеийн үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд удирдах, гүйцэтгэх чадавхийг сайжруулж, гамшгийн эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж хэвшүүлнэ.

6.3.9. Гамшгийн нөхцөлд бүх нийтийн бэлэн байдлын чадавхийг дээшлүүлэх, бие бялдар, сэтгэл зүйн хөгжлийг нь дэмжихэд чиглэсэн “Иргэний боловсрол” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

6.3.10. Эх оронч үзлийг төлөвшүүлж, цэргийн насны иргэдийн цэргийн боловсролыг дээшлүүлнэ.

6.4 Төрийн албаны хүний нөөцийн бодлого ба нийгмийн баталгаа

6.4.1. Төрийн албаны хүний нөөцийг төрийн бодлогоор бэлтгэж, төрийн албан хаагчдыг тасралтгүй сурч, хөгжих боломжоор хангах зорилгоор “Төрийн албан хаагчийн сургалт” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

6.4.2. Төрийн албан хаагчдыг улс төрийн дарамт, хамааралгүй, ажлын байран дээрээ аль болох тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.

6.4.3. Төрийн албаны томилгоог хийхдээ мэдлэг мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлагыг нь харгалзан зөвхөн чадахуйн зарчимд суурилсан, шатлан дэвших зарчим баримтлана.

6.4.4. Төрийн албан хаагчдын“Нийгмийн баталгаа” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

6.4.5.Цалин хөлс, орлогод нь нийцсэн, эдийн засгийн дарамтгүй“Төрийн ажилтны орон сууц” -хөтөлбөрийг төрийн албан хаагчдад зориулан хэрэгжүүлнэ.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО



ХӨТӨЛБӨРИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛСАН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Нэг. Хөтөлбөрийг дараах эрх зүйн болон бодлогын баримт

бичгүүдэд нийцүүлэн боловсрууллаа. Үүнд:

1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль
3. Улс төрийн намын тухай хууль
4. “Алсын хараа -2050” хөгжлийн хөтөлбөр
5. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл
6. “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөн
7. “Хүнсний хангамж, аюулгүй байдал” хөтөлбөр
8. “Шинэ сэргэлтийн бодлого”
9. “Шинэ хоршоо” хөдөлгөөн
10. Нийгэм, эдийн засгийн салбарт хэрэгжиж буй Үндэсний хөтөлбөрүүд
11. Монгол Ардын Намын 2024 оны УИХ-ын сонгуульд оролцох “ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО – БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН РЕФОРМ” мөрийн хөтөлбөр
12. Дархан хотыг 2020-2035 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн Ерөнхий төлөвлөгөө
13. Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн хөгжлийн үндсэн чиглэл
14. Аймаг, орон нутагт хэрэгжиж буй бодлого, хөтөлбөр, төслүүд
15. УИХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцох зарим нам, эвслийн мөрийн хөтөлбөр

Мөн Их, дээд сургуулийн консерциум (14 санал), сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд (16 санал), Шарын гол сумын ахмад настнууд (73 санал), Сувилагчдын холбоо (21 санал), Улаанбаатар гурил ХХК (26

санал), УБТЗ ХНН (29 санал), ДДЦС ТӨХК(6 санал), ДДС ХК(11 санал), ТБЦДС ТӨХК(9 санал), Дархан Төмөрлөгийн үйлдвэр ТӨХК(3 санал), Бурхантын хөндийн замчид ТББ (6 санал), Дархан АЗЗА ТӨХК (5 санал), МАНамын гишүүд (29 санал), Шарын гол сумын ЗДТГазар (44 санал), МАНамын үүрүүд (25 үүр1052 санал), аймгийн ЗДТГазрын ХБТХОХэлтэс (13 санал) зэрэг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдээс давхардсан тоогоор 1357 санал ирүүлснийг нэгтгэн судалж, ихэнх саналуудыг төсөлд тусгалаа.

Хоёр. Аймгийн Монгол Ардын Намын Хорооноос 2020 оны орон нутгийн ээлжит сонгуульд оролцсон 5 бүлэг, 17 дэд бүлэг, 215 зорилт арга хэмжээ бүхий “Тогтвортой бодлого - Тогтвортой хөгжил” мөрийн хөтөлбөр дээр үндэслэн аймгийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулсан байна.


Уг хөтөлбөрт Намын мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээнүүд шууд болон шууд бусаар бүгд (66 зорилт, 283 арга хэмжээ) орсон бөгөөд 2023 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилт **96,15** хувийн биелэлттэй байна. Үүнээс:

- 238 арга хэмжээ 100%,
- 24 арга хэмжээ 90%,
- 14 арга хэмжээ 70%,
- 3 арга хэмжээ 50%,
- 4 арга хэмжээ 30 % тус тус биелэлттэй байна.

Энэхүү хөтөлбөрт тусгагдсан зорилтуудаас:

- Элэг бүтэн Монгол,
- Эрүүл Дарханчууд,
- Хавдаргүй Дархан,
- Эрүүл шүд,
- Шилэн эмнэлэг,
- Цахим эмнэлэг
- Боловсрол – 2032,
- Оюунлаг Дарханчууд,
- Цахим сургууль,

- Гоё сургууль,
- Гоё цэцэрлэг,
- Чадварлаг багш,
- Эрүүл чийрэг эр хүн,
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр,
- Цагийн ажил,
- Эрсдэлгүй Дархан,
- Биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөр,
- Ногоон Дархан -2032,
- Хүнсний хувьсгал,
- Утаагүй Дархан,
- Шарилжгүй Дархан,
- Уулзвар
- Дугуйн зам,
- Иргэний Индэр,
- Цахим засаглал зэрэг 25хөтөлбөр, төсөл, аяныг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тусгалаа.



Гурав. Аймгийн Монгол Ардын Намын Хорооноос 2024 оны орон

нутгийн ээлжит сонгуульд оролцохоор 6 бүлэг, 27 дэд бүлэг, 272 зорилт арга хэмжээ бүхий “ТОГТВОРТОЙ БОДЛОГО– ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ, ШИНЭ СЭРГЭЛТ – ШИНЭ ХОТ” мөрийн хөтөлбөрийн төслийг боловсрууллаа.

3.1 Хөтөлбөрийн төсөлд тусгасан хөгжлийн бодлогын баримт бичгүүд:

- “Тогтвортой ажилтан” хөтөлбөр,
- “Багшийн хөгжил” хөтөлбөр,
- “Орон нутгийн тэтгэлэг” хөтөлбөр,
- Хүн ам зүйн нэгдсэн бодлого,
- “Халамжаас хөдөлмөрт” хөтөлбөр,
- “Цалинтай эх, эцэг” хөтөлбөр
- “Ахмадаас суралцъя” аян,
- “Хоггүй хот” төсөл,
- “Түрээсийн сууц” төсөл,
- “Кинонд ээлтэй хот” төсөл,
- “Атар – IY” аян,

- “Шинэ хоршоо” хөдөлгөөн,
- “Өрх бүр үйлдвэрлэгч” хөтөлбөр,
- “Ажил олгогч өрх, иргэн” хөтөлбөр,
- “Соёлтой үйлчилье” аян,
- “Эрсдэлгүй, стрессгүй, ээлтэй, соёлтой, цэвэрхэн Дархан” хөтөлбөр,
- “Шинэ хөдөө” төсөл,
- “Бичил бизнесийг дэмжье” төсөл,
- “Иргэний боловсрол” хөтөлбөр,
- “Төрийн албан хаагчийн сургалт” хөтөлбөр,
- “Нийгмийн баталгаа” хөтөлбөр,
- “Төрийн ажилтны орон сууц” – хөтөлбөр,
- “Эко жорлон”,
- “Үнс” хөтөлбөр,
- “Нийтийн тээврийн тусгай бодлого” зэрэг 25 хөтөлбөр, төсөл хэрэгжүүлж, аян өрнүүлнэ.

3.2. Хөтөлбөрийн төсөлд тусгасан хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлууд:

- ❖ Бүсийн хэмжээний лавлагаа шатлал (3 дугаар шатлал)-ын “Нэгдсэн эмнэлэг”,
- ❖ Бүсийн хэмжээний “Багш хөгжлийн төв”-ийн өргөтгөл,
- ❖ Бүх сургуулиудад лаборатори, зарим сургуулиудад туршилтын талбай,
- ❖ “Хөдөө аж ахуйн их сургуулийн хотхон”,
- ❖ “Дундын дадлага, үйлдвэрлэлийн бааз”,
- ❖ “Номын сан, музейн цогцолбор”,
- ❖ “Спорт, урлагийн төрөлжсөн сургууль”,
- ❖ “Биеийн тамир, спортын бүсийн хөгжлийн төв”,
- ❖ “Мөсөн ордон”,
- ❖ “Ногоон хэрэм”,
- ❖ “Ойн зурвас”,
- ❖ “Хамгаалалтын зурвас”,
- ❖ “Амралт, зугаалгын бүс”,
- ❖ “Ботаникийн болон ховор ургамлын цэцэрлэгт хүрээлэн”,
- ❖ “Бага оврын үйлдвэр”,
- ❖ “Гангийн үйлдвэр”,
- ❖ “Дархан арьс, ширний цогцолбор”,

- ❖ “Хүнд үйлдвэрлэлийн технологийн парк”,
- ❖ “Хөнгөн үйлдвэрлэлийн технологийн парк”,
- ❖ “Тэжээлийн үйлдвэр”,
- ❖ “Техник, тоног төхөөрөмж угсрах үйлдвэр”,
- ❖ “Бизнесийн төв”,
- ❖ “Мини цэцэрлэгт хүрээлэн”,
- ❖ “Залуус хороолол”,
- ❖ “Шинэ суурьшлын бүсүүд”,
- ❖ “Олон улсын тээвэр, ложистикийн төв”,
- ❖ “Цэнэглэх станц”,
- ❖ “Хүнсний ногооны зоорь”,
- ❖ “Үр үржүүлгийн төв”,
- ❖ “Эко түлшний үйлдвэр”,
- ❖ Шарын гол – Баянгол - Улаанбаатар чиглэлийн авто зам,
- ❖ Энхтал багийн төвийг Дархан – Хушаат чиглэлийн авто замтай холбох төсөл,
- ❖ “Хүлэмжийн аж ахуйн цогцолбор”,
- ❖ “Эрчим хүчний хоёрдогч эх үүсвэр”,
- ❖ “Трубин генераторын шинэчлэлт”,
- ❖ “Агаарын шугамын тойрог схем”,
- ❖ “Хэрэгцээний халуун усны хаалттай систем”,
- ❖ “Ухаалаг тоолуур”,
- ❖ “Дулаан хуваарилах төвүүд”,
- ❖ Дулаан Шарын гол ТӨХК-ийн “Дулааны станцын өргөтгөл”,
- ❖ “Сумдын цэвэрлэх байгууламжийн өргөтгөл”,
- ❖ “Тусгай хог хаягдлын цэг”,
- ❖ “Хүүхэд, залуучуудын хөгжлийн төв”,
- ❖ “Ухаалаг систем”,
- ❖ “Хамгаалалттай бүс”,
- ❖ Өргөх станц, усан сан”-зэрэг 40 гаруйбүтээн байгуулалтын төсөл шинээр хэрэгжих болно.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО